МЭДЭЭ · 2024 оны 6-р сарын 5

БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН ЗЭЭЛ ТЭТГЭЛЭГТЭЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХУУЛИЙН ХҮРЭЭНД ЯВАГДСАН ЭСЭХИЙГ ТОГТООХ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААГ ӨРГӨН ХҮРЭЭНД ЯВУУЛЖ БАЙНА



Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн алба болон Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч нарын хамтарсан ажлын хэсгээс мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа Боловсролын зээлийн сантай холбоотой хэрэгт Нийслэлийн прокурорын газраас хяналт тавин ажиллаж байна.

Боловсролын зээлийн сангийн зээл тэтгэлэгтэй холбоотой үйл ажиллагаа хуулийн хүрээнд явагдсан эсэхийг бүрэн шалгаж, тогтоохын тулд мөрдөн шалгах ажиллагааг өргөн хүрээнд явуулж байна. Тодруулбал, 1997-2023 оны хооронд тус сангаас гадаад улсын магистр, доктор, дэлхийн шилдэг их дээд сургуульд бакалаврын хөтөлбөрт хамрагдах 2288 суралцагчид олгосон зээл тэтгэлэг, үүнээс 941 суралцагчид олгосон 47,1 тэрбум төгрөгийн зээлийг чөлөөлсөн үндэслэлийг хянан үзэж, авлига албан тушаалын гэмт хэрэг үйлдэгдсэн эсэхийг шалгаж байгаа юм.

Өнөөдрийн байдлаар ажлын хэсгээс зээл тэтгэлэгт хамрагдсан 2115 суралцагч, мөн 2017 оноос хойш зээлээс чөлөөлөгдсөн 200 гаруй хүний хувийн хэрэг, материалтай танилцан, 1600 гаруй хүнээс гэрчийн мэдүүлэг авч, тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн Боловсролын зээлийн санд эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан 2 хүнд Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 2 /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/-т зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, шалгалтын ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байна.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад нийт 269 суралцагч 1.4 сая ам.доллар буюу 4,8 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг хийжээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1211